- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

НДЕГ-ын Хяналт шалгалтын газраас хийсэн хяналт шалгалтын мөрөөр шимтгэлийн өр авлага бууруулах ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагатай гэж үзсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилт, өмнөх шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шалгалтын газраас шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилган, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилго бүхий төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэж, тус хэлтсийг цаашид “Ажил сайжруулах” шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод аудитын тасагтай бөгөөд хэлтсийн даргын баталсан “Дотоод аудитын төлөвлөгөө”, НДЕГ-ын 2022 оны 01

дүгээр сарын 05-ны өдрийн 06/16 тоот албан бичгээр өгөгдсөн чиглэлийн дагуу сайн дурын даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны үндэслэл, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, тус хэлтсийн санхүү бүртгэлийн тасгаар санхүүгийн тайланд тусгагдсан тодорхойгүй өглөгийн бүртгэлийг гаргуулж санхүүгийн тайланд залруулга бичилт хийхийг санхүү бүртгэлийн тасгийн даргад зөвлөмжөөр үүрэг өгч ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2018 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,542,378.0 мянган төгрөгөөр буюу 8.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,622,911.7	10,758,338.2	-864,573.5
Урьдчилгаа	0	0	
Авлага	6,706,127.9	5,973,189.9	-732,938.0
Бараа материал	14,339.5	15,440.3	1,100.8
Үндсэн хөрөнгө	574,144.6	628,177.3	54,032.7
Нийт хөрөнгө	18,917,523.7	17,375,145.7	-1,542,378.0
Өр төлбөр	1,086,241.5	738,552.7	-347,688.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,831,282.2	16,636,593.0	-1,194,689.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	18,917,523.7	17,375,145.7	-1,542,378.0

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс 864,573.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ үзүүлэлт нь тэтгэврийн даатгалын сангаас олгох дараа сарын тэтгэвэр тэтгэмжийн санхүүжилтийг байршуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 5,973.189.9 мянган төгрөг болж 732,938.0 мянган төгрөгөөр буурсан нь санхүүгийн тайлан дахь авлагыг бууруулж, эзэн холбогдогч, авлага үүссэн шалтгаан

нөхцөлийг тодруулж илрүүлсэн бөгөөд санхүүгийн тайланд залруулга дансны бичилт хийхийг санхүү бүртгэлийн тасгийн даргад зөвлөмжөөр үүрэг өгч ажилласантай холбоотой байна

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 27,881.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, НДЕГ-аас 350.0 мянган төгрөгийн баримт бичгийн бор хавтас, даатгуулагчдад олгох 1,419.8 мянган төгрөгийн үнэт цаас маягтуудыг үнэ төлбөргүй хүлээж авсан бөгөөд 28,550.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Нийт 1,769.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь дансны үлдэгдлийг 1,100.8 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/159, А/194 дүгээр тушаалаар тус хэлтэст хуваарилсан 80,090.0 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг шилжүүлэн хүлээн авч, А/193 дугаар тушаалаар цаашид ашиглах боломгүй 8,962.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталж данснаас хасаж бүртгэсэн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 26,057.2 мянган төгрөг байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 738,552.7 мянган төгрөг болж 347,688.8 мянган төгрөгөөр буурсан нь санхүүгийн тайлан дахь өглөгийг бууруулж, хариуцах эзэн, өглөг үүссэн шалтгаан нөхцөлийг тодруулж, тайлант хугацаанд бусад өглөг нэмж үүсгэлгүй 412,682.3 мянган төгрөг байсныг 292,601.3 мянган төгрөг буюу 70,9 хувьд хүргэн бууруулж ажилласантай холбоотой нийт өглөг буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16,636,593.0 мянган төгрөг болж 1,194,689.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд үйл ажиллагааны зардалд 1,091,718.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр тэтгэмжийн зардалд 80,078,348.6 мянган төгрөг, нийт 81,170,067.5 мянган төгрөгийн зардлыг төлөвлөж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 29,106,492.8 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолоор тус хэлтсийн төсвийн төслөөс 2022 оны үйл ажиллагааны зардлыг 194,552.1 мянган төгрөгөөр бууруулж 897,166.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 611,538.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 80,689,886.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлогыг 14,024,261.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 30,695,191.7 мянган төгрөгөөр, улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 12,435,562.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолыг үндэслэн 2 удаа тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 8 арга хэмжээний зардалд НДЕГ-ын даргын А/192 тоот тушаалаар 103,746,141.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны зардалд 913,979.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн зардалд 102,832,161.5 мянган төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Тайлант онд НДЕГ-аас тэтгэврийн даатгалын санд 58,003,901.8 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 150,000.0 мянган төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний

даатгалын санд 4,558.7 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 280,000.0 мянган төгрөг, нийт 58,438,460.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, улсын төсвөөс 14,158,109.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлогоор 39,491,961.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 118,236.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 136.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сан болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих үйл ажиллагааны санхүүжилтэд 904,202.3 мянган төгрөг, нийт 113,111,106.3 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, тэтгэвэр тэтгэмжийн зардалд 102,849,038.2 мянган төгрөгийг, үйл ажиллагааны урсгал зардалд 898,110.1 мянган төгрөг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдлээс 10,171,018.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71901 –Нийгмийн даатгал 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	839,968.0	835,695.3	4,272.7	100%
2	71901 –Нийгмийн даатгал 80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	5,670.0	5,547.8	122.2	100%
3	71901 –Нийгмийн даатгал 80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал	2,400.0	2,400.0	0.00	100%
4	71901 –Нийгмийн даатгал 80224-Зөвлөл, хороо, комиссын гишүүд	22,865.0	21,255.7	1,609.3	93.0%
5	71901 –Нийгмийн даатгал 80802 -Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	22,472.0	22,472.0	0.00	100%
6	71901 –Нийгмийн даатгал 80813-Хуульд заасан үндэслэлээр алба	2,300.0	2,300.0	0.00	100%
7	71901 –Нийгмийн даатгал 80820-Бусад тусламж, дэмжлэг зардал	8,527.1	8,439.0	88.1	99.0%
	Үйл ажиллагааны зардлын дүн	913,979.8	898,110.1	-15,869.7	98.3
8	Нийгмийн даатгалын сан Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	102.832.161.5	102, 849,038.2	-16,876.7	100.02%
	Нийт дүн	103,746,141.3	103,747,148.3	-1,007.0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансанд Жинсрэгт хайрхан ХХК-аас 1,000.0 мянган төгрөгийн хандив авч, байгууллагын нэрэмжит тэмцээн уралдаан зохион байгуулахад зориулан зарцуулж тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллага тайлангийн хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71901- Нийгмийн даатгалын үйл ажиллагаа	2022.01.01-2022.12.31	Үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах	Бүрэн хэрэгжсэн, биелэлт 98.3%	913,979.8	898,110.1
2	Нийгмийн даатгалын сан Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2022.01.01-2022.12.31	Нийгмийн даатгалын сангийн үйлчилгээг хүргэх 4	Бүрэн хэрэгжсэн, биелэлт 100%	102.832.161.5	102, 849,038.2

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 44 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн тайланг, нэгтгэсэн тайлантай хамт 2023 оны 3 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга болон цаасаар цахимаар ирүүлэх бусад материалуудыг шаардаж бүрдүүлж хавсаргалаа.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтээр Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын 81,587,053.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 1,223,805.8 мянган төгрөгөөр тогтоож гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0% буюу 917,854.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хавсаргаж, ирүүлсэн байна. Үүнд: НДҮЗ-ийн 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолоор тодотгол хийж урсгал зардлуудаас нийт 2,721.7 мянган төгрөгөөр бууруулан баталсан бөгөөд төсвийн жилийн явцад батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэх арга хэмжээгээ бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж 2 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 5,551.7 мянган төгрөгийг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 172.4 мянган төгрөгийг, 31 удаа сургалт сурталчилгаа зохион байгуулснаас 5 удаагийн сургалтыг цахимаар зохион байгуулж албан томилолтын зардлаас 152.4 мянган төгрөгийг, бусад зардлуудаас 351.9 мянган төгрөгийг, нийт 6,228.4 мянган төгрөгийн хэмнэлтийг төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3004 орлогын мөнгөн гүйлгээнээс 2136 гүйлгээг хугацаа хоцроож, 3153 зарлагын мөнгөн гүйлгээнээс 2263 гүйлгээг хугацаа хоцроож байршуулан өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 15 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны цэсэд төсвийн гүйцэтгэл хэмнэлтийн тайлбарыг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар шивж оруулаагүй, PDF форматаар байршуулсан нь холбогдох заалттай нийцээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус хэлтсийн даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/76 тушаалаар 36 ажилтанд 9,900.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо эрх зүйн үндэслэлийг тодорхой дурдаагүй бөгөөд санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулаагүй зөрчил байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан зарим мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 4 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн 1 зөвлөмжийг аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 1 зөвлөмж, 3 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 436 тоотой ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	208,545.4	3	208,454.4	100
Зөвлөмж	1	0.00	1	0.00	100
Нийт дүн	4	208,545.4	1	208,545.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Нийгмийн даатгалын сангийн тайлан, журнал, холбогдох санхүүгийн баримт шаардлагатай цахим материалууд, нэгдсэн тайлангийн иж бүрдэл зэргийг хангаж ажиллахад санхүү бүртгэлийн ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх асуудлыг анхаарал татахуйц асуудлаар тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нэмэлт санхүүжилтийн тайланг зэрэгцүүлэх зарчмын дагуу тайлагнаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулга хийгээгүй зэргээс нийт 6.666.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 11,304.3 мянган төгрөгийн 5 зөрчил илэрсэнд, 392.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 10,911.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

НДЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 22-ны Б/201 тушаал болон Төв аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны А/755 захирамжийг үндэслэн 392.7 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхар олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Нийгмийн даатгалын сангийн тайлан, журнал, холбогдох санхүүгийн баримт шаардлагатай цахим материалуудыг хугацаанд нь ирүүлээгүй, мөн нэгдсэн тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн улирлын болон жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабрын дагуу боловсруулж, тайлагнана”, 13.2-д “Аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн хагас жилийн болон жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасан цаглабрын дагуу, нийгмийн даатгалын төв байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан цаглабрын дагуу тус тус боловсруулна.” Төсвийн тухай хууль 5 дугаар зүйл. 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн

аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, 8.9.2-д “төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” заалтуудтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “толилуулга”, “үнэлгээ ба хуваарилалт”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Шатах тослох материалын зарлагын гүйлгээг шалгахад тайлангаар тайлагнасан шатах тослох материалын 1,011.6 мянган төгрөгийн шатахууныг жолоочийн замын хуудсыг үндэслэн нормативын дагуу тооцоо бодсон баримтаар баталгаажуулаагүй, бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “ангилал”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх

2.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Тус хэлтсийн даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/76 тушаалаар 36 ажилтанд 9,900.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо эрх зүйн үндэслэлийг тодорхой дурдаагүй бөгөөд санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулаагүй зөрчил байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Тушаал шийдвэрт хууль зүйн үндэслэл, шалтгаан, зориулалт, зорилгыг тодорхой бичиж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүжүүлэх эх үүсвэрийг зөв тодорхойлох

3.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг гүйцэтгэхэд хугацаа хэтрэлт 64,3 хувьтай зөрчил байна. Үйл ажиллагааны мэдээнд батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бичээгүй, Нийгмийн даатгалын сангийн мэдээний батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг шивж оруулаагүй, зөвхөн PDF форматаар хавсаргасан, байгууллагын дарга нягтлан бодогч нарын нэр утас, цахим хаяг байршаагүй зэрэг зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 5 дугаар зүйлийн 5.1.3-д "тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх" гэж заасантай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "оршин байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Үнэн зөв, бодитой, ойлгомжтой, иж бүрэн мэдээллийг батлагдсан маягтаар хуулийн хугацаанд нь байршуулж хэвших.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							залруулсан		залруулаагүй			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны тайланд нэмэлт санхүүжилийн дансанд өмнөх оны гүйцэтгэлийг зэрэгцүүлэх зарчмын дагуу тайлагнаагүй , төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулга хийгээгүй зэргээс нийт 6.666.4 мянган төгрөгийн алдаа гарсан байна.	1	6,666.4			1	6,666.4	1	6,666.4				
Дүн	1	6,666.4	0	0.0	1	6,666.4	1	6,666.4	0	0.0	0	0.0

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Нийгмийн даатгалын сангийн тайлан, журнал, холбогдох санхүүгийн баримт шаардлагатай цахим материалуудыг хугацаанд нь ирүүлээгүй, нэгдсэн тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй зөрчил байна	1	0			1	0						
Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Э-д НДЕГ-ын даргын 2022.12.22-ны Б/201 тушаалаар 100 хувийн цалингаар мөнгөн урамшуулал олгосон байхад, Төв аймгийн засаг даргын 2022.12.26-ны А/755 захирамжийг үндэслэн 40 хувийн ҮДМУ давхар тооцож олгосон зөрчил байна. / 981.720*40 хувь /	1	392.7	1	392.7								
Шатах тослох материалын зарлагын гүйлгээг шалгахад тайлангаар тайлагнасан шатах тослох материалын 1.011.6 мянган төгрөгийн шатахууныг жолоочийн замын хуудсыг үндэслэн нормативын дагуу тооцоо бодсон баримтаар баталгаажуулаагүй, бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан зөрчил байна.	1	1011.6					1	1011.6				
Дүн	3	1,404.3	1	392.7	1	0.0	1	1,011.6	0	0.0	0	0.0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг гүйцэтгэхэд хугацаа хэтрэлт 64,3 хувьтай зөрчил байна. Үйл ажиллагааны мэдээнд батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бичээгүй бөгөөд, НДСангийн мэдээний батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг шивж оруулаагүй, зөвхөн PDF форматаар хавсаргасан зөрчил байна.	1	0							1	0
Дүн	1	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	1	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Тус хэлтсийн даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/76 тушаалаар 36 ажилтанд 9,900.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо эрх зүйн үндэслэлийг тодорхой дурдаагүй бөгөөд санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулаагүй зөрчил байна.	1	9,900.0							1	9,900.0
Дүн	1	9,900.0	0	0.0	0	0.0	0	0.0	1	9,900.0
Нийт дүн	1	9,900.0	0	0.0	0	0.0	0	0.0	1	9,900.0